

## ОРЧИН ҮЕИЙН ЯПОНЫ ФИЛОСОФИЙН ТӨЛӨӨЛӨГЧ НИШИ АМАНЭ-ГИЙН ТУХАЙ

Д. Оюунгэрэл (Доктор, Ph.D)  
МУИС, ШУС, Философи, шашин судалын тэнхим

**Тулхүүр үс:** оюун ухаан, үндэсний үзэл, Мэйжийн шинэчлэл, өрнө дорнын үзлийн ялгаа, соёл, хөгжил

**Төвч агуулга:** Япончууд орчин үеийн өндөр хөгжилтэй орон болох үндсээ Мэйжийн шинэчлэлээр тавьсан бөгөөд 1868 онд хаант засгаа сэргээн тогтоосон тус шинэчлэлийг удирдсан нэгэн залуу самурай засгийн газрыг тулхэн унагажээ. Үүний үр дүнд 1880-аад оны дунд үе гэхэд уламжлалт нийгмийн бүтэц бүхэлдээ задраад зогсохгүй шинэ бүтэц бий болсноос гадна цаашид хурдацтай хөгжих улс төр, эдийн засаг, оюун санааны хөрс нэгэнтэй бий болсон байв. Өөрчлөлт шинэчлэлтийг дагасан үйл ажиллагааны дагуу философиин шинэчлэлийн зорилго нь нэр томъёоны нэрийл, засвараас эхлээд ямар үзэл сургаал шинэ нийгмийг бий болгоход тулхэц болох вэ? гэдэгт мөн чанар нь оршиж байв. Энэ үйл явцад буюу орчин үеийн нийгэм бий болгоход оюун санааны түүчээ болсон олон философич төрөн гарсны нэг нь Ниши Аманэ мөн билээ.

\* \* \* \* \*

Орчин үеийн японы философиин нэг гол төлөөлөгч бол Ниши Аманэ (1829-1897) бөгөөд түүнийг япон дахь барууны философиин эцэг, японы соёлын өв уламжлалыг алдагдуулалгүйгээр Мейжийн шинэчлэлийг зөв хийхэд улгэр дуурайлал болсон сэтгэгч хэмээн ном зохиолд үнэлэн бичжээ.

Ниши Аманэ нь тухайн үеийн Ивами мужид хягадын анагаах ухаанаар мэргэшсэн самурай эмчийн гэр бүлд төрж, багаасаа хягад хэл сурч, Күнзийн сургаалыг судалж эхэлсэн байна. Тэрээр Мейжийн шинэчлэлийн үед аж төрж байсан хүн учраас гадаад ертөнцтэй харилцах харилцаанд туйлын талархалтай хандаж, орчуулагч болох зорилго тавин шаргуу хичээллэж эхэлсэн гэдэг.

Урьд өмнө нь гарч байгаагүй нийгэм түүхийн нөхцөлтэй уялдан XVIII зууны эхэн үеэс японд өрнийн мэдлэг ухаан, соёл илүү хурдацтай хөгжсөн. Шинэчлэлийн үйл явц тийм ч дардан шулуун байгаагүй ажээ. Гаднаас орж ирсэн шинэ мэдлэгийн хэлбэр үндэсний уламжлалт үзэл баримтлалтай тулгарч, улмаар японы үндэсний үзлийг улам лавшуулсан. Гэсэн хэдий ч Күнзийн сургаалыг номлогчид уламжлалт мэдлэг боловсролоо баримтлахын сацуу өрнийн мэдлэг ухаанаас тухайлбал, анагаах ухаан, философи, биологи, астрономи, уран барилга зэргээс суралцахын чухлыг ойлгож, улмаар практикт нэвтрүүлсэн нь их амжилтыг олжээ.

Мейжийн шинэчлэлийн эхэн үед зарим сэхээтэн өрнөдийн техник технологийн төрөл зүйл, шинжлэх ухааны мэдлэгийн аль алиныг нь шинтогийн төрийн албаны үзэл баримтлал, Күнзийн сургаалтай хослуулахыг зорьж, нөгөө талаар орчин үед үндэсний нийгэм-ёс суртахуун ба соёлын амьдралд зориулсан бодлогыг үндэслэн бий болгохыг эрхэмлэж байлаа.

Залуу сэхээтнүүдийн ихэнх нь японы философиин түүхийн тэрхүү эрчимтэй шинэчлэлийн үед өөрсдийн уламжлалт шинто-күнзийн сургаал номлогоос илүү өрнийн философиин үзэл санаа, ойлголтуудыг илүүд үзэж байжээ. Тэдний нэг бол Ниши Аманэ юм.

Ниши Аманэ 1865 оноос Мэйжийн өөрчлөлтийн аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож эхэлсэн байна. Тэрбээр барууны үзэл сургаалыг тууштай дэмжин холбоо харилцаа тогтоохыг уриалж байсан бөгөөд өрнөдтэй холбоо тогтооход нөлөөлөх дотоодын эсэргүүцэл нь японы хөгжил, дэвшилд сөргөөр нөлөөлөх вий хэмээн болгоомжилж байсан. Ниши Аманэ өрнийн философийт танилцаж, дорнын болон өрнийн соёлын хоорондын ялгааг ойлгохыг хичээж байжээ. Түүний сонирхлыг позитивизм, утилитаризм, эмпиризм илүү татах болж, хэд хэдэн өгүүллийг бичиж нийтлүүлсэн нь амжилтанд хүрсэн байна. Утилитарист Ж.С.Миль болон позитивизмын төлөөлөгч О.Контын философиийг японд сурталчилж, улмаар 1874 онд утга зохиол, байгалийн шинжлэх ухаан, математик, шашин, улс төр, философиин ойлголтуудыг тайлбарласан нэвтэрхий толь бичсэн нь тухайн үед японд цоо шинэ байж, философиийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэжээ. Ийнхүү Күнзийн сургаал, Шинто шашны уламжлалт үзэл санаанаас өөр үзэл сургаалыг японд сурталчилсан түүний хичээл зүтгэлээр Мэйжийн шинэчлэл, өөрчлөлтийн талаарх эерэг сэтгэлгээ нь япончуудад нөлөөлж, хувьсгалын үр дүнг ойлгох боломжийг олгож, улмаар амжилтанд хүрч чадсан хэмээн түүнийг хойч үеийнхэн нь үнэлдэг ажээ.

Ниши Аманэгийн зохиосон нэвтэрхий толийн чухал хэсэг бол түүний философиийн талаарх тайлбар гэж үздэг. Ниши Аманэ философиийн судалгааг хэд хэдэн дэд сэдэвт хувааж, тэр дотроо хамгийн чухал нь логик хэмээн үзэж байсан байна. Тэрээр философиийг “*tetsugaku*” (哲学) хэмээх шинэ нэр томъёогоор японы философиийн түүхэнд хэрэглэсэн нь эдүгээ түүнийхээр нэгэнт хэвшиж тогтжээ. Энэхүү ойлголт нь “мэргэн ухаан”, “суралцах, судлах” гэсэн утга бүхий хоёр үгнээс гаралтай юм.

Тэрээр орчуулгын нэлээдгүй бүтээл туурвисан бөгөөд түүний анхны орчуулгын бүтээл нь “Олон улсын хууль” нэртэй бүтээл байдаг.

Тэрээр өрнийн философиийг судлахыг тууштай зорьж, ном бүтээл орчуулж туурвисны нэг нь “The Theory of Aesthetics”<sup>1</sup> хэмээх бүтээл бөгөөд энэ нь орчин үеийн японы философиид гоо зүйн чиглэлийн анхны бүтээл байсан төдийгүй өөрөө мөн анхны чухал телөөлөгч болон түүхэнд үлдээжээ. Учир нь тэрээр японы философиид гоо зүйн шинэ шинэ нэр томъёог боловсруулан хэрэглэсэн хүн юм. Тэрээр Декартын “Би сэтгэж байна. Иймээс би оршин байна” хэмээх алдарт ишлэлээс “Би мэдрэч байна. Иймээс оршин байна” хэмээн өөрийн гоо зүйн үзлээ тайлбарлажээ. Тэрээр гоо зүйн дотоод элемент гэж нэрлэгддэг зүйл бол хүний мэдрэмж юм хэмээгээд түүнийг илэрхийлдэг ойлголтуудыг тайлбарласан байна.

Мэйжийн шинэчлэлийн үед онцлон хэлбэл, 1873 оноос судлаач эрдэмтдийн үүрэг ролийг өндөрт үнэлж, мэргэжлийн хүрээлэнг байгуулан тэдний хичээл зүтгэлийг ашиглаж эхэлжээ. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зорилго нь ард түмнийг сурган хүмүүжүүлэх, гэгээрүүлэхдэд чиглэж байв. “Шинэ нийгмийг бүтээн босгохын тулд улс төрийн үйл ажиллагаа болон ёс суртахууны үүрэг хариуцлагаа ухамсарласан хүн амтай байх хэрэгтэй”<sup>2</sup> хэмээн Ниши Аманэ үзэж байсан нь тийн хүрээлэнгийн зорилготой нийцсэн бөгөөд тус хүрээлэнд орж ажилласан нь түүний үйл хэргийг улам тодотгосон хэрэг болжээ.

Тэрээр багаасаа судалсан Күнзийн сургаалыг тэр дундаа түүний ёс суртахууны сургаалыг бүхэлдээ япончуудад тохирохгүй, шинэ нийгмийг бий болгоход чухал ач холбогдолтой биш хэмээн үзэж байсан ч японы өв уламжлалыг үл тоомсорлохоос болгоомжилж байв. Тиймээс күнзийн сургаалын уламжлалыг өрнийн философи, тэр дундаа pragmatik философиийн нэгтгэн тайлбарлахыг зорьж эхэлсэн байна.

Шинэ нийгмийг бүтээн босгохын тулд ёс суртахууны үүрэг хариуцлагаа ухамсарласан

<sup>1</sup> Тус бүтээлийг /“*Bitemufgaku setsu*”/ 1877 онд хэвлүүлснээр орчин үеийн японы гоо зүйн үндэс суурийг тавигч хэмээн тооцогддог.

<sup>2</sup> James W. Heisig, Thomas P. Kasulis, John C. Maraldo. *Japanese Philosophy A Sourcebook*. University Hawaii Press. 2011. P 69-70

иргэдтэй байх хэрэгтэй хэмээн үзэхдээ тэрээр ёс зүйн асуудлуудыг тайлбарлан бичиж, иргэдэд сурталчилж эхэлжээ. Түүний үзлээр, “ёс суртахуун нь хүний үл ажиллагааны бүх хүрээнд байдаг зүйл бөгөөд оршин байхын үндэс”<sup>3</sup> хэмээн үзжээ. Машин ажиллахын тулд түүний эд анги бүрэн бүтэн байх ёстoin нэгэн адил улс орон хөгжихөд ёс суртахууны үүрэг хариуцлагыг иргэдэд бүрэн төлөвшүүлсэн байх ёстой. Ниши Аманэ нь хүний нийгмийн хамтын амьдралын суурь зарчим бол:

Нэгдүгээрт, ёс суртахуун,

Хоёрдугаарт, хууль нь хэмээн үзсэн. Тийн ёс суртахууны төлөвшилд анхаарч байж улс орны хөгжил дэвшил, ирээдүйн сайн сайхан хамаарах тухай түүний санаа япончуудын талархлыг хүлээжээ. Хөгжил дэвшилд хүрэхийн тулд япончууд үнэт зүйлээ ёс суртахуун хэмээн үзэх ёстогт тэрээр өөрийн илтгэлүүдээрээ дамжуулан илэрхийлж, ёс суртахуун нь эрүүл мэнд, эд баялаг, мэдлэгийн гол суурь болно хэмээн үзсэн.

Ниши Аманэ тухайн үедээ Японы эрх баригчид дээрх турван зүйлийг зорилго болгож, тэдгээрт хамаатай аливаа үл явдлыг дэмжих үүрэг хүлээх ёстой гэж үзсэн. Тэрээр Мэйжийн шинэчлэлийн хүрээнд үндэсний хучирхэг байдлыг бэхжүүлэх нь хууль сахих, тэнцвэрт байдлыг хангах замаар хөгжлийн бодлогыг боловсруулж, эрүүл мэнд, эд баялаг, мэдлэгийг олж авах нь сайн засаглалын гол түлхүүр гэдгийг өөрийн сургаалдаа онцолж байжээ.

Дүгнэлт: Тус өгүүлэлд Ниши Аманэгийн амьдрал, үл хэргийг товч танилцуулсны зэрэгцээ цаашид түүний философиийн үзэл санааг япончуудын уламжлалт үзэл санааг хэрхэн дүгнэж тайлбарлаж байснаас гадна хүний мөн чанарын тухай, гоо зүйн үзлийн тухай гэсэн үндсэн судлагдахуунаар дэлгэрүүлэн судлах боломжтой.

Өнөөдөр бид дэлхийн олон орны сэтгэгчдийн авч үзэж байсан философиийн түгээмэл асуудлуудыг мөн нэгэн адил зэрэгцүүлэн судалж, нөгөө талаар тэдний үзэл санаанд үндэсний дэвшилтээ өв уламжлал нь хэрхэн тусч, шинэ нийгмийг байгуулав? гэдэг нь илүү сонирхолтой, ач холбогдолтой байх юм. Өгүүлэлд дурдагдан буй Ниши Аманэ нь өрнийн философиийг тууштай баримтлагч нэгэн хэдий ч үндэсний өв уламжлалаа угүйсгэгч нэгэн байгаагүй юм.

Орчин үеийн японы философиийн нэгэн чухал дүр төрх бол өөрчлөлт шинэчлэлтийн дүнд өөрсдийн дэвшилтээ үндэсний өв уламжлалаа улам баяжуулан, лавшуулан тодотгож, үндэсний үзэл, үндэсний мэдрэмж, өөрийн төрөлх хандлагыг үндэслэхэд чиглэсэн байдаг. Өрнийн философиийн үзэл баримтлалыг судлан суралцаж, хөгжих явцад ч өөрийн сэтгэлгээний үндсэн агуулгыг улам тодруулахыг зорьсон байдаг. Өрсөлдөгч соёлоо судалж, өөрийн давуу талыг олж харахын учир ийм ажээ.

Япончууд өөрийн оюун санааны түүхээ бусад улс оронд, тухайлбал, барууныханд танилцуулах зорилгоор өөрийн философичдын ном бүтээлийг сурталчлах барагүй ажил хийдэг бөгөөд түүний нэлээд томоохон төлөөлөгч бол Масао Абэ юм. Тэрээр нэгэнтээ “Японд философи байдаг уу?” хэмээх асуулт надад барагүй ирдэг хэмээгээд энэ асуултанд “Барууныхан японыг урлаг, утга зохиол, эдийн засаг, технологийн хөгжил дэвшилээр мэддэг бөгөөд энэ нь өнгөц юм. Харин японы оюун санааны түүхийн талаарх мэдлэг нь сийрэг хэвээр байна” хэмээн Нишида Китарогийн “Сайн үйлийн тухай сургаал” хэмээх номын өмнөтгөлд бичсэн байна. Японы философиийн түүхэнд олон сэтгэгч төрөн гарсан бөгөөд гагцхүү Мэйжийн шинэчлэлийн үед өрнийн философи сэтгэлгээ, үзэл онолтой танилцаж, улмаар японы орчин үеийн философийт боловсруулах үл явц өрнөж түүнд тодорхой амжилт гаргасан сэтгэгч бол дээр бидний өгүүлсэн Ниши Аманэ юм .

<sup>3</sup> Kyoichi Kazue and Toru Sagara. Japanese Ethics. (*Nihon no rinri*) Tokyo, 1959. P 23

## ABSTRACT

As mentioned above, among the campaigners for Japanese enlightenment in the early Meiji era, Nishi Amane was prominent for his philosophical achievements. He introduced European philosophy into Japan, especially the positivism of Auguste Comte and the utilitarianism of John Stuart Mill. The academic philosophy of modern Japan owes its origins to him. For this reason, Nishi is often called “the father of philosophy in Japan. According to Nishi, every human being, however uncivilized he/she may be, possesses the same nature (性). Human nature embraces “為群ノ性 (igun no sei: nature to build society)” and all elements essential to maintain and develop a society, such as morality and law, can be. Though a Confucian by upbringing, Nishi Amane became thoroughly committed to Western intellectual values in his programs for the new Japanese society. In his roles of teacher, writer, and government administrator, he was influential at one of the most critical times in Japan’s history.

## НОМ ЗҮЙ

1. Japanese Thought in the Meiji Era, ed. Masaaki Kosaka. trans. Abosch David. Tokyo, 1958
2. James W. Heisig, Thomas P. Kasulis, John C. Maraldo. Japanese Philosophy A ourcebook. University Hawaii Press. 2011
3. Kyoichi Kazue, “The Career and Thought of Nishi Amane” (Nishi Amane no shōgai to sono shisō). Tokyo, 1970
4. Kyoichi Kazue and Toru Sagara. Japanese Ethics. (*Nihon no rinri*) Tokyo, 1959
5. Modern Japanese Aesthetics: A Reader.
6. Nishida Kitaro. An Inquiry into the Good. Yale University Press. Translated by Masao Abe and Christopher Ives. London. 1990
7. Yoshiteru Aso. History of Recent Japanese Philosophy. (Kinsei Nikon tetsugakushi) Tokyo, 1942